



Бизнесийн Ёс Зүйн Алба

Бие Даасан Гишүүний Биеэ авч явах Дүрэм. Асуулт ба Хариулт

Та өөрийн түүхээ хуваалцаж, Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн болон бизнес боломжуудын талаар цахим хуудсандаа мэдээлэл оруулах бүртээ та өөрийн бизнесийг сурталчилж байдаг. Herbalife Nutrition-ын бизнесийн аливаа мэдэгдэл, түүх, бүтээгдэхүүний зураг, аудио/видео бичлэг зэрэг нь таны бизнесийн сурталчилгаа болж байдаг.

Энэ төрлийн бүх мэдэгдэл хууль ёсны, үнэн зөв, төөрөгдүүлсэн биш байх ёстой.

Энэхүү гарын авлагад бид дараах дүрмүүдийн талаар түгээмэл тохиолддог **Асуулт ба Хариултыг** танд толилуулж байгаадаа баяртай байна:

- Орлого ба амьдралын хэв маягийн талаарх мэдэгдэл
- Жин зохицуулалтын үр дүнгийн талаарх мэдэгдэл
- Бүтээгдэхүүний хэрэглээний талаарх мэдэгдэл
- Бизнес боломжуудын талаарх мэдэгдэл

Орлого ба амьдралын хэв маягийн талаарх мэдэгдэл

1. Орлого ба амьдралын хэв маягийн талаарх мэдэгдэл гэж юу вэ?

Бие даасан Гишүүний бодит болон боломжит орлогын талаарх аливаа мэдэгдэл, нотолгоо, мэдээлэл нь "Орлогын мэдэгдэл" гэж тооцогдоно.

Амьдралын хэв маягийн талаарх мэдэгдэл нь Гишүүний баримталж буй амьдралын хэв маяг, худалдан авалт, Herbalife Nutrition бизнест хэрхэн амжилтанд хүрч буйг харуулсан мэдэгдэл юм. Машин, аялал, байшингийн зураг зэрэг нь Орлого болон амьдралын хэв маягийн мэдэгдэл юм.

2. Орлогын талаар ямар мэдэгдэл хийхийг хориглодог вэ?

Орлогын талаар хориотой мэдэгдлийн жишээ:

- «таны амьдралын баталгаа»
- «сая саяыг олно»
- «төсөөлж байгаагаас чинь ч илүүг олно»
- «асар их ашиг, орлого», «баяжина»
- «хялбар орлого», «ямар ч хүчин чармайлтгүй орлого», «идэвхгүй орлого»

Бие даасан Гишүүдэд бодит бус, хэт өндөр хүлээлт үүсгэж болзошгүй мэдэгдлүүд хориотой.

3. Би Herbalife Nutrition-ын Бизнес боломжуудын талаар ярихдаа, тодорхой түвшинд орлогын баталгаа өгч болох уу?

Болохгүй. Гишүүдэд тодорхой хэмжээний орлогыг амлах эсвэл бодит бус, хэт өндөр хүлээлт үүсгэхийг хориглодог. Жишээлбэл: "хялбар орлого", "идэвхгүй орлого", "баяжина", "таны амьдралын баталгаа" гэх мэт.

4. Herbalife Nutrition арга хэмжээн дээр би өөрийн орлого ба амьдралын хэв маягийнхаа талаар хуваалцаж болох уу?

Herbalife Nutrition компанийн сургалт, арга хэмжээ, уулзалтууд дээр та өөрийн орлого болон амьдралын хэв маягийнхаа талаар дунджаас дээгүүр түвшинд ярьж, хуваалцаж болно. Таны ярьж буй мэдэгдэл нь үнэн зөв байх ёстой ба хэт их орлогын талаар болон хүчин чармайлтгүй хялбар, хурдан үр дүнг амлах ёсгүй.

Жишээлбэл, та өөрийн машин (тансаг зэрэглэлийн жагсаалтад ороогүй), байр, завь, аялал, үнэт эдлэл, гоёл чимэглэл гэх мэт зүйлсийн гэрэл зургуудыг үзүүлэх боломжтой.

Тансаг зэрэглэлийн машины жагсаалтыг компанитай холбогдож эсвэл MyHerbalife.com сайтаар нэвтрэн авах боломжтой.

Таны мэдэгдэл нь бусдыг төөрөгдүүлэхгүйн тулд та дараах зүйлсийг анхаарах ёстой:

- таны харуулж буй орлого, амьдралын хэв маягт хүрэхийн тулд тухайн хүний хүчин чармайлт, өөрийн баг командтайгаа тогтмол хамтран ажиллах ажиллагаа, зохих ур чадвар, хичээл зүтгэл, тууштай байдал чухал гэдгийг онцлон тэмдэглэх;
- одоогийн үр дүнд хүрэхийн тулд та хэр их цаг хугацаа зарцуулснаа тусгах;
- эдгээр үр дүн нь баталгаатай биш бөгөөд хүн бүрийн үр дүн харилцан адилгүй гэдгийг сануулах;
- орлого¹ болон амьдралын хэв маяг²-ын талаарх санамжийг хавсаргах

*Олон нийтийн сүлжээ дээр нийтлэхэд хориглох санамж болон, нийт дүрмийн санамжийг энэхүү сүүлчийн хуудаснаас харах боломжтой.

5. Тансаг амьдралын хэв маягийн талаарх мэдэгдэл гэж юу вэ?

Тансаг амьдралын хэв маягийн талаарх мэдэгдэл нь хэт баян тансаг амьдралын хэв маягаар амьдарч буй тухай мэдээлэл юм.

Жишээлбэл:

- Тансаг харш - Элит, дээд зэрэглэлийн, тансаг, сүрдмээр том байшин.
- Тансаг зэрэглэлийн машин – дундаж машинуудтай харьцуулахад стандартаас давсан, өндөр үнэтэй, тансаг зэрэглэлийн машин
- Тансаг зэрэглэлийн машины жагсаалтыг Компанид хандаж эсвэл MyHerbalife.com сайтаар нэвтэрч авах боломжтой.
- Хувийн дарвуулт онгоц, хувийн онгоц, нисдэг тэрэг.

Энэ төрлийн мэдэгдэл нь дөнгөж бизнесээ эхлүүлж буй хүмүүст хүрэхэд хэцүү үр дүнг амлаж, бусдыг төөрөгдүүлдэг учир хориотой. Ийм мэдэгдэл нь Бие Даасан Гишүүн эсвэл дундаж орлоготой үйлчлүүлэгчийн хувьд бодит бус, өндөр хүлээлт үүсгэж болзошгүй байдаг.

6. Би өөрийн цахим хуудсандаа сард 2000 ам.долларын орлого олж буй талаараа нийтэлж болох уу?

Болохгүй. Сарын 1000 ам.доллараас хэтрэхгүй орлогын талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээнд нийтлэхийг зөвшөөрдөг. Ийм нийтлэлд та орлогын тухай мэдэгдлийг хавсаргасан байх ёстой¹.

7. Уулзалт арга хэмжээн дээр үг хэлэх, илтгэл тавих үедээ би өөрийн орлогынхоо тухай дурдаж болох уу?

Орос, Украин, Монгол, Казахстаны Бие даасан Гишүүд илтгэлийн үеэр өөрийн орлогын талаар дурдаж болох бөгөөд энэ нь "Жилийн дундаж орлогын тайлан"³-д заасан жилийн орлогын хэмжээнээс хэтрэхгүй байна.

- Орос - жилд 3,026,656 рубль
- Украин - жилд 971.272 гривен
- Монгол Улс - жилд 173,284,244 төгрөг
- Казахстан - жилд 16,298,275 тенге

Армени, Азербайжан, Гүрж, Израиль, Киргизстан, Узбекистан, Беларусь, Эстони, Литва, Латви улсын Бие Даасан Гишүүд жилд 100,000 ам.доллараас хэтрэхгүй орлогын талаар дурдах боломжтой.

Хэрэв таны жилийн орлого дээрх дүнгээс давсан бол та дараах байдлаар илэрхийлж болно: "Миний орлогын хэмжээ зургаан оронтой тоогоор хэмжигддэг."

Орлогын тухай ярихдаа дараах зүйлсийг анхаарна уу:

- таны үзүүлсэн орлого, амьдралын хэв маягт хүрэхийн тулд тухайн хүний хүчин чармайлт, өөрийн баг командтайгаа тогтмол хамтран ажиллах үйл ажиллагаа, зохих ур чадвар, хичээл зүтгэл, тууштай байдал чухал гэдгийг онцлон тэмдэглэх;
- одоогийн үр дүнд хүрэхийн тулд та хэр их цаг хугацаа зарцуулснаа тусгах;
- эдгээр үр дүн нь баталгаатай биш бөгөөд хүн бүрийн үр дүн харилцан адилгүй гэдгийг сануулах;
- орлого¹ болон амьдралын хэв маяг²-ын талаарх санамжийг хавсаргах;

¹Олон нийтийн сүлжээ дээр нийтлэхэд хориглох санамж болон, нийт дүрмийн санамжийг энэхүү сүүлчийн хуудаснаас харах боломжтой.

Жин зохицуулалтын үр дүнгийн талаарх мэдэгдэл

8. Би өөрийн жин зохицуулалтын үр дүнгээ сургалт, уулзалт арга хэмжээ дээр хуваалцах эсвэл үр дүнгээ өөрийн цахим хуудсандаа байршуулж болох уу?

Болно. Үр дүн нь гэрэл зургаар, аудио/видео бичлэгээр эсвэл бичгээр болон амаар гэдгээс үл хамааран санамжийг үргэлж давхар хавсаргаж өгөх хэрэгтэй.

9. Би үйлчлүүлэгчдийнхээ жин зохицуулалтын хөтөлбөрийн үр дүнгийн зургийг олон нийтийн сүлжээнд хуваалцаж болох уу?

Тиймээ болно. Та өөрийн үйлчлүүлэгчийн зураг, жин хассан түүхийг яриа, нийтлэлдээ ашиглахдаа үйлчлүүлэгчээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай. Жин зохицуулалтын тухай бүх гэрэл зураг, түүхэнд санамжийг хавсаргасан байх ёстой⁴.

10. Зөвхөн Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүнийг хэрэглэснээр та хүссэн жиндээ хүрнэ гэж мэдээлж болох уу?

Болохгүй. Тэнцвэртэй зөв хооллолт, байнгын дасгал хөдөлгөөн, өдөр бүр хангалттай хэмжээгээр шингэх уух нь жин хасах, хянах хөтөлбөрийн нэг хэсэг гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

11. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь нэг өдрийн хооллолтыг бүрэн орлодог бөгөөд энэ байдлаар хооллож хүссэн жиндээ хүрэх боломжтой гэж мэдээлж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын зарим бүтээгдэхүүн нь өдөр тутмын хооллолтын нэг удааг орлох зориулалттай бөгөөд таны нэг өдрийн бүрэн хооллолтыг орлож болохгүй тул дор хаяж нэг удаа энгийн тэнцвэртэй зөв хооллох ёстой. Тэнцвэртэй зөв хооллолт нь жингээ хасах, эрүүл байх гол түлхүүр гэдгийг анхааруулан тэмдэглэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүний хэрэглээний талаарх мэдэгдэл

12. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний хэрэглээний талаар би ямар мэдэгдэл хийж болох вэ?

Зөвхөн бүтээгдэхүүний шошгон дээр буюу Herbalife Nutrition компанийн гаргасан материалд дурьдагдсан зөвшөөрөгдсөн мэдэгдлийг хийх ёстой. Та Herbalife Nutrition бүтээгдэхүүний орц найрлагын шинж чанарын талаар ярьж болно, гэхдээ эдгээр шинж чанарыг тухайн бүтээгдэхүүнтэй холбож өгөхгүй байх нь чухал юм.

Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүний орц найрлагын талаар бүрэн тайлбарыг компанийн албан ёсны хуудас MyHerbalife.com сайтаас авах боломжтой.

13. Би Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний найрлагын эмийн шинж чанарын талаар олон нийтийн сүлжээнд хуваалцаж болох уу?

Та Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний орц найрлагын шинж чанарын талаар ярьж болно, гэхдээ эдгээр шинж чанарыг тухайн бүтээгдэхүүнтэй холбохгүй байх хэрэгтэй.

Жишээлбэл:

- «Алоэ ургамал нь биеэс хорт бодисыг гадагшлуулахад тусалдаг» -болно, учир нь Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүний орц найрлагыг бүрдүүлэгч хэсгийн шинж чанарын тухай ярьж байгаа юм.
- "Алоэ ургамлын ундаа нь биеэс хорт бодисыг гадагшлуулахад тусалдаг" – Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүнийг анагаахын үг хэллэгтэй холбож тайлбарлаж болохгүй

Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний орц найрлагын талаар бүрэн тайлбарыг компанийн албан ёсны хуудас MyHerbalife.com сайтаас авах боломжтой.

*Олон нийтийн сүлжээ дээр нийтлэхэд хориглох санамж болон, нийт дүрмийн санамжийг энэхүү сүүлчийн хуудаснаас харах боломжтой.

Бүтээгдэхүүний орц найрлагын тайлбарыг олон нийтийн сүлжээнд нийтлэхдээ Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний зургийг оруулж болохгүй.

14. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь аливаа өвчнөөс урьдчилан сэргийлдэг гэж хэлж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүн нь аливаа өвчнийг оношлох, эмчлэх, эдгээх буюу аливаа өвчнөөс урьдчилсан сэргийлдэг гэж ярих буюу Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний эмчилгээний шинж чанарын тухай тайлбарлахыг хориглоно.

Зөвшөөрөгдсөн үг хэллэг нь " өөрийгөө илүү сайнаар мэдрэх", "энерги нэмэгдүүлэх ", "нойрны чанарыг сайжруулах" гэх мэт юм.

15. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүнийг хэрэглээд эмчлэгдсэн, эдгэрсэн талаар тохиолдлуудаас дурдаж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь аливаа өвчнийг оношлох, эмчлэх, эдгээх буюу аливаа өвчнөөс урьдчилсан сэргийлдэг гэж ярих буюу Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүний эмчилгээний шинж чанарын тухай тайлбарлахыг хориглоно.

Зөвшөөрөгдсөн үг хэллэг нь " өөрийгөө илүү сайнаар мэдрэх", "эрч хүч, энерги нэмэгдэх ", "нойрны чанар сайжрах" гэсэн үгнүүд юм.

16. Миний үйлчлүүлэгч надад жингээ хасах хүсэлтээр хандсан боловч уг үйлчлүүлэгч элэгний өвчтэй тохиолдолд би юу хийх ёстой вэ?

Энэ тохиолдолд Бие даасан Гишүүн:

1. Үйлчлүүлэгчдээ Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүнийг хэрэглэхээс өмнө заавал эмчид хандахыг зөвлөх;
2. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь үйлчлүүлэгчийн тань эрүүл мэндийн асуудлыг шийдэхэд тусална гэж зөвлөж болохгүй. Үйлчлүүлэгчдээ буруу ташаа мэдээлэл өгөх нь аливаа өвчнөөр шаналж буй үйлчлүүлэгчид тань аюул учруулж болзошгүй. Энэ нь таны үйлчлүүлэгчийн эмнэлэгт хандаж, эмч мэргэжилтнээр зохих эмчилгээг хийлгэхээс татгалзахад хүргэх магадлалтай.

Ийм үйлдэл нь таны бизнест аюул учруулж болзошгүй бөгөөд тухайн үйлчлүүлэгч таны нэр хүндэд халдах болон хууль эрх зүйн асуудалд хүргэж, шүүхэд нэхэмжлэл гаргаж болох эрсдэлтэй.

Энэхүү дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд Гишүүний гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах боломжтой.

17. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь Ковид19-ыг эмчлэхэд тустай эсвэл энэ вирусээс хамгаалах үйлчилгээтэй гэж ярьж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь аливаа өвчнөөс, тэр тусмаа Ковид19- ээс урьдчилан сэргийлэх, эмчлэхэд тустай гэж мэдээлж болохгүй.

18. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй бол эрүүл мэндэд нь нөлөөлнө гэж мэдээлж болох уу?

Болохгүй.

19. Миний эрүүл амьдралын хэв маягийн клубын үйлчлүүлэгч Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүнийг хэрэглэсний дараа эрүүл мэнд, архаг хууч өвчин нь хэрхэн сайжирсан талаараа хуваалцаж болох уу?

Та үйлчлүүлэгчийнхээ яриаг эелдгээр зогсоож, түүний жин хасалт болон эрүүл мэнд нь сайжирч буй үр дүнг сайшааж, Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүн нь аливаа өвчнийг оношлох, эмчлэх, эдгээх буюу аливаа өвчнөөс урьдчилсан сэргийлдэггүй гэдгийг анхааруулах нь зүйтэй. Зөвшөөрөгдсөн үг хэллэг нь " өөрийгөө илүү сайнаар мэдрэх", "эрч хүч, энерги нэмэгдэх", "нойрны чанар сайжрах" гэсэн үгнүүд юм.

20. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүнийг хүүхдэд хэрэглэхийг зөвлөж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition нь 18 ба түүнээс дээш насны хүмүүс хэрэглэх албан ёсны гэрчилгээтэй тул бүтээгдэхүүнийг 18-аас доош насны хүүхдэд хэрэглэхийг зөвлөдөггүй.

21. Би бүтээгдэхүүнээ жирэмсэн байх үедээ эсвэл хүүхдүүддээ хэрэглэж байсан хувийн туршлагаа өөрийн цахим хуудсандаа эсвэл уулзалт, сургалтын үеэр хуваалцаж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын бүтээгдэхүүнийг жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, 18-аас доош насны хүүхдэд хэрэглэх албан ёсны гэрчилгээгүй болно.

Бүтээгдэхүүний хэрэглээг та болон таны үйлчлүүлэгчийн хувийн сонголт гэдгийг давхар анхааруулсан байсан ч энэ төрлийн сурталчилгаа хориотой.

Бизнес боломжуудын талаарх мэдэгдэл

22. Би Herbalife Nutrition-ын бизнесийг ажилтны хувиар сурталчилж болох уу?

Болохгүй. Бие даасан Гишүүн нь Herbalife Nutrition-ын бизнесийг бие даасан бизнес хэлбэрээр төлөөлөх ёстой.

23. Би Herbalife Nutrition компанид ажилладаг гэж хэлж болох уу?

Болохгүй. "Ажил" гэдэг үгийг, "хөлсөөр ажиллах / хөдөлмөрийн гэрээгээр ажиллах" гэсэн утгаар ашиглаж болохгүй.

Зөвшөөрөгдсөн үг хэллэг:

- Би ... дэх жилдээ Herbalife Nutrition бизнесээ эрхэлж байна.
- Би ... оноос бизнесээ эрхэлж эхэлсэн
- Би Herbalife-д ... жил
- Би компанитай ... жил хамтран ажиллаж байна

24. Би Herbalife Nutrition-ын бизнесээ хагас болон бүтэн цагаар эрхэлж болох бизнесийн боломж гэж сурталчилж болох уу?

Тийм ээ, болно.

25. Би Herbalife Nutrition компанитай хамтран ажилладаг гэж хэлж болох уу?

Тийм ээ, болно.

26. Би Herbalife Nutrition-ын бизнестээ «цалин», «ажилтан» гэсэн нэр томъёог ашиглаж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын бизнес нь таны бие даасан бизнес бөгөөд ажил хөдөлмөр эрхлэлт гэж ярих нь зохимжгүй.

27. Би Herbalife Nutrition-ын бизнестээ өөрийгөө «хоол тэжээлийн зөвлөх, мэргэжилтэн гэсэн нэр томъёог ашиглаж болох уу?

Болохгүй. Тухайн мэргэжлээр тусгай боловсролын гэрчилгээтэй байж «мэргэжил» гэсэн нэр томъёог ашиглана.

Та «үйл ажиллагаа» эсвэл «бизнес» гэсэн нэр томъёог ашиглаж болно.

28. Би уулзалт дээр үг хэлэхдээ, бизнесээ эхлүүлэхдээ зээл авсан гэдэг талаараа дурдаж болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын бизнес боломжийг ашиглах зорилгоор өр тавих буюу зээл авахыг компани огт дэмждэггүй.

29. Цар тахлын үед би Herbalife Nutrition-ын бизнес эрхлэх нь таны санхүүгийн асуудлаа шийдэхэд тусална гэж сурталчилж болох уу?

Болохгүй. Түүнчлэн, Herbalife Nutrition бизнест цар тахалтай холбоотой үг хэллэг хэрэглэхийг хориглоно. Жишээлбэл: "цаг үеэс үүдэлтэй ажилгүйдэл", "ажилгүйдлийн дээд амжилт", "гэртээ байх", "хорио цээр", "өөрийгөө тусгаарлах".

30. Herbalife Nutrition-ын бизнесийг идэвхгүй орлогын эх үүсвэр гэж ойлгож болох уу?

Болохгүй. Herbalife Nutrition-ын бизнесийг амжилттай эрхлэхэд тухайн хүний цаг, хүчин чармайлт, өөрийн баг командтайгаа тогтмол хамтран ажиллах ажиллагаа, хичээл зүтгэл, тууштай байдал чухал байдаг.

¹ Орлогын талаарх мэдэгдлийн санамж:

- «Үзүүлсэн орлогын хэмжээ, бизнес хөгжүүлэлтийн аргууд нь тодорхой хувь хүний жишээ бөгөөд бүгд харилцан адилгүй болно.» (бүх улс оронд хамааралтай).
- «Үзүүлсэн орлогын хэмжээ, бизнес хөгжүүлэлтийн аргууд нь тодорхой хувь хүний жишээ бөгөөд бүгд харилцан адилгүй болно. Гишүүдийн боломжит орлогын талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.Herbalife.com болон www.MyHerbalife.com сайт дээрх компанийн жил бүрийн урамшууллын тайлангаас харна уу» (Орос, Украин, Казахстан, Монгол улсад хамааралтай. Заавал хэрэглэх).
- President's Team-ын статустай бол: Үзүүлсэн орлогын хэмжээ нь борлуулалтаар тэргүүлэгч Herbalife Nutrition Бие Даасан Гишүүний орлогын 1%-тай тэнцүү байна. Гишүүдийн боломжит орлогын талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.Herbalife.com болон www.MyHerbalife.com сайт дээрх Herbalife Nutrition компанийн жилийн дундаж урамшууллын тайлангаас харна уу» (Орос, Украин, Казахстан, Монгол улсад хамааралтай).

Олон нийтийн сүлжээн дээр нийтлэхийг хориглодог мэдэгдлийг дараах холбоосоор татах боломжтой
https://hrbl.me/INC_SM_MN_mn



"Санамж" – олон нийтийн сүлжээнд нийтлэх зурган дээр байршуулах тайлбар бичгийг дараах холбоосоор татах боломжтой.
https://hrbl.me/INC_over_MN_mn



² Амьдралын хэв маягийн талаарх мэдэгдлийн санамж: «Дурьдагдсан амьдралын хэв маяг нь тодорхой нэг хүний жишээ бөгөөд хүн бүрийн хэв маяг харилцан адилгүй болно.

³ Herbalife Nutrition компанийн жилийн дундаж урамшууллын тайланг дараах холбоосор харах боломжтой
https://hrbl.me/SAGC_MN



⁴ Жин зохицуулалтын үр дүнгийн мэдэгдлийн талаар санамж:

"Жин хянахтай холбоотой аливаа мэдэгдэл нь тэнцвэртэй зөв хооллолт, тогтмол дасгал хөдөлгөөн, өдөр тутмын ууж буй шингэний хэмжээ, шаардлагатай бол нэмэлт тэжээл, хангалттай амрах зэргийг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, Herbalife-ын хоол тэжээлийн жин зохицуулалтын хөтөлбөртэй холбоотой. Хүн бүрийн үр дүн харилцан адилгүй байдаг.

Олон нийтийн сүлжээн дээр нийтлэхийг хориглосон мэдэгдлийг холбоосоор харах боломжтой
https://hrbl.me/WL_SM_MN_mn



"Санамж" – олон нийтийн сүлжээнд нийтлэх зурган дээр байршуулах тайлбар бичгийг дараах холбоосоор татах боломжтой.
https://hrbl.me/WL_over_MN_mn

